



МОНГОЛ УЛС

Хот дахин төлөвлөлтийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эрх зөрчигдсөөр байна. Эрүүгийн хуулийг хүний эрх хамгаалагч, сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад ашигласан. Уул уурхайн төслүүдийн хүрээнд олон нийтийн оролцоо, зөвлөлдөх үйл явц хангалтгүй хэвээр байв.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Засгийн газар хоёр ч удаа солигдсон нь авлига, шударга, ёс зүйтэй байдлын талаарх олон нийтийн санаа зовнилыг тод харууллаа. Төрийн өндөр албан тушаалтнууд шүүхийн бие даасан, хараат бус байдлыг ноцтойгоор сулруулсан олон нийтийн мэдэгдлийг удаа дараа хийв.

ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн төслүүдийн нөлөөлөлд өртсөн хүмүүст зөвшилцөх хангалттай цаг хугацаа олгож, мэдээллээр хангасангүй. Тэд газар болон өмч хөрөнгийг нь бодит байдлаас доогуур, амьжиргааг нь дордуулан үнэлснийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрсэн. Өрхийн бизнесийг доогуур үнэлэх эсхүл огт үнэлэхгүй байх, үнэлсэн ч хөрөнгийн үнэлгээний тайланг нь гаргаж өгөөгүй байна. Улсын Их Хурлаас нөлөөлөлд өртсөн бүлгүүд энэ асуудлаар гомдол гаргах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжийг олгосон үр дүнтэй механизм бий болгож, зохих хууль эрх зүйн хамгаалалтаар хангасангүй.

ЭРҮҮЛ ОРЧИНД АМЬДРАХ ЭРХ

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг (БОНУ) хийх хууль эрх зүйн шаардлагуудыг эс тооцвол уул уурхайн төслүүдэд олон нийтийн оролцоог хангах, зөвлөлдөх үйл явц ихэвчлэн хэлбэр төдий, давчуу, хүртээмжгүй байдлаар зохион байгуулагдаж байна.¹ Орон нутгийн удирдлагууд (Баг) малчдыг амьдралд нь нөлөөлөх шийдвэр гаргахад оролцуулдаггүй, ихэнх малчид БОНУ-ний талаар мэдээлэлгүй байдаг. Уул уурхайн үйл ажиллагаа болон холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалт нь бэлчээрийн хомсдол, доройтолд хүргэж, малчдын нүүдлийн зам, бэлчээрийг хувааж, тэдний нүүдлийн уламжлалт амьжиргааны тогтвортой байдалд аюул учруулж байна.

ТАЙВАН ХУРАН ЦУГЛАХ ЭРХ ЧӨЛӨӨ

Эрх баригчид тайван жагсаал цуглаан хийх эрхээ эдэлж буй хүмүүсийг гуравдагч этгээдийн халдлагаас хамгаалсангүй. 2025 оны нэгдүгээр сарын 12-нд

Сүхбаатарын талбайд болсон жагсаалын үеэр хууль сахиулагчид жагсагчдын биед халдсан бүлэг хүмүүсийн үйлдлийг зогсоох арга хэмжээ авсангүй.²

Тавдугаар сард Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн хүүгийн тансаг хэрэглээний талаарх мэдээлэл нийгмийн сүлжээнд ил болсноор олон нийт бухимдал, дургүйцлээ илэрхийлсэн. Энэ нь Ерөнхий сайдыг огцрохыг шаардсан залуучуудын 21 хоногийн тайван жагсаалыг өдөөж, улмаар Засгийн газар огцорсон.

Нэгдүгээр сарын 23-нд Монгол Улсын Их Хуралд өргөн барьсан Жагсаал цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл (шинэчилсэн найруулга) оны эцэст хэлэлцэгдсэнгүй үлдэв.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

Эрүүгийн хуулийг хүний эрх хамгаалагч, сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагуудын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах, мэдээлэл түгээхийг хориглоход ашигласан. Үндсэн Хуулийн Цэц “худал” болон “ташаа” гэх мэт хэт тодорхой бус нэр томъёонд үндэслэн ийм хязгаарлалт тогтоох нь хууль ёсны эсэхийг хэлэлцэх хүсэлтийг хүлээн авч, арваннэгдүгээр сарын 25-ны өдөр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Үндсэн хууль зөрчсөн хэмээн шийдвэрлэсэн.

ШУДАРГААР ШҮҮЛГЭХ ЭРХ

Гуравдугаар сарын 17-нд цагдаа нар Ноорог креатив студио хэвлэл мэдээллийн байгууллагын оффист нэгжлэг хийж, тоног төхөөрөмж, хувийн утаснуудыг нь хураан авав. Ноорогийн ажилтнуудын мэдээлснээр тэднийг Эрүүгийн хуулийн 19.9.1 дүгээр зүйлд заасан “үндэсний эв нэгдлийг бусниулах” гэмт хэрэгт сэжиглэн шөнөжин саатуулж, байцаасан нь шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтэд санаа зовниход хүргэлээ.³

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

Долоодугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын 48 дугаар тогтоолоор Хүчирхийллийн эсрэг үндэсний хороо байгуулагдсан. Энэ нь гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх хүчин чармайлт болохыг Засгийн газар онцолсон ч, жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа технологи ашиглан үйлдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийг өргөн хүрээнд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой мэдээлсэнгүй. Холбогдох хууль тогтоомжийг бэхжүүлэх талаарх зөвлөмжүүд ч хэрэгжсэнгүй.

¹ Mongolia: Suggested Recommendations to Mongolia for its Review during the 50th Session of the UPR Working Group, November 2025, 25 August

² “Mongolia: We must protect people who are exercising their right to listen”, 14 January (Mongolian only).

³ “Mongolia: Targeting one to scare thousands, undermining the right to a fair trial”, 24 March

Эмнести Интернэшнл нь хүн бүрд эрхийг нь эдлүүлэхийн төлөө хүмүүсийн хүнлэг сэтгэлд тулгуурлан кампанит ажил өрнүүлдэг 10 сая хүнийг эгнээндээ нэгтгэсэн дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн юм.

Бид эрх баригчид олон улсын эрх зүй, хэм хэмжээг хүндэтгэдэг, хариуцлагаа хүлээдэг, амлалтдаа хүрдэг дэлхий ертөнцийг бий болгохын төлөө ажилладаг.

Бид аливаа улс төрийн үзэл баримтлал, шашин, эдийн засгийн ашиг сонирхлоос ангид байж, гишүүд дэмжигчдийнхээ хандив тусламжаар санхүүждэг.

Монголын Эмнести Интернэшнл

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж, #АВ төвийн 7 давхар 701 тоот

Утас/Факс: 976-7000-4705

members@amnesty.mn

www.amnesty.mn